

НИЙСЛЭЛИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ АЛБАНЫ ДАРГА, ДЭД ДАРГА, АХЛАХ  
ГҮЙЦЭТГЭГЧ, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧ НАР ДҮҮРГИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН  
АНХАН ШАТНЫ 1 ДҮГЭЭР ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ, ШҮҮГЧ НАРТАЙ  
ЗӨВЛӨЛДӨХ УУЛЗАЛТ ХИЙСЭН ХУРЛЫН ПРОТОКОЛ

2014.04.02

Улбаанбаатар хот

Зөвлөлдөх уулзалтанд Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Э.Батбаяр, дэд дарга, дэд хурандаа, Ч.Оюунцэцэг, Хан-Уул дүүргийн ахлах гүйцэтгэгч, ахмад Ц.Бямбасүрэн, Баянгол дүүргийн ахлах гүйцэтгэгч, ахмад Б.Дашдаваа, 139 дүгээр тойргийн шийдвэр гүйцэтгэгч П.Хадбаатар, Дүүргийн иргэний хэргийн нэгдүгээр шүүхийн ерөнхий шүүгч Б.Баатар, шүүгч Б.Золзаяа, С.Амардэлгэр, Г.Билгүүн, Б.Сайханцэцэг, Ө.Уянга, Б.Солонго нар оролцон Дүүргийн иргэний хэргийн нэгдүгээр шүүхийн ерөнхий шүүгч Б.Баатарын өрөөнд 10.00 цагаас 12.00 цагийн хооронд болов

Ерөнхий шүүгч Б.Баатар:

- Шүүгч нарыг танилцуулав..

Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх албаны дарга, хурандаа Э.Батбаяр:

Албаны очсон бүрэлдхүүнийг танилцуулав.

Ерөнхий шүүгч Б.Баатар:

- Танай байгууллагаас хүсэлт тавьсны дагуу зөвлөлдөх уулзалт зохион байгуулж байна, манай шүүгч нарт санаа оноо юу байна.
- Шүүгч Б.Золзаяа: За танай албатай холбогдуулж хэлэхэд:
- Итгэмжлэгдсэн төлөөлөгчөө дуудсан цагт ирүүлж байх, шүүхэд нотлох баримтыг хурдан гаргаж өгөх шаардлагатай. Танай шийдвэр гүйцэтгэгч нар дуудсан цагт ирдэггүй, удаа дараа дуудуулдаг, ирэхгүй болохоор нь бид албаны даргыг мэдэгдэх хуудсаар шүүх дууддаг. Шүүхэд нотлох баримтыг гаргаж өгөхдөө нэхэмжлэлийн шаардлагын хэмжээнд гаргаж өгөөд байдаг, шүүх асуудлыг шийдвэрлэхдээ шийдвэр гүйцэтгэх ажиллагааны бүх үйл явцыг нотлох баримтаар авч үзэх шаардлагатай байдаг. Энэ нь дахин дахин гомдол гаргах нөхцөл бүрдүүлэхээс сэргийлж хаалт хийж өгч байдаг. Нэг төрлийн хэрэг дээр олон удаа гомдол гаргадаг, шүүх нэхэмжлэлийг авахгүй гэх эрх байдаггүй. Шүүхэд гаргаж буй нотлох баримтыг заавал нотариатаар баталгаажуулсан байх шаардлагатай. Та нарын хувьд асуудал их байдаг байх. Бид иргэний хуулийн төсөлд саналаа өгч байгаа. Шийдвэр гүйцэтгэгч хэзээ хүчтэй байх уу, төрийн албадлагыг хэрхэн хэрэглэх вэ гэдэг тал дээр та нар ч гэсэн саналаа өгөх хэрэгтэй. Дэлхий нийтийн жишиг харахад Шийдвэр гүйцэтгэгчид торгодог, баривчилдаг эрхтэй байж байж бидний гаргасан шийдвэр биелэгдэнэ.

Шүүгч Б.Сайханцэцэг:

- Танай байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгч нар гомдлын шаардлагыг анхаарахгүй байна, шал өөр нотлох баримт гаргаж өгдөг, шүүх хуралдаанд мэтгэлзэхгүй, идэвхгүй байна, шүүхэд төлөөлдөг тусгайлсан хүн байх хэрэгтэй болуу гэж санагддаг. Бас нэхэмжлэлээ гардаг авдаггүй, шүүх хуралд хувийн амбицаар ханддаг. Бид бие биедээ хүндэтгэлтэй хандах хэрэгтэй

байна.Шийдвэр гүйцэтгэгч нар их ядмаг байна, гомдол гарагчтай шүүгч мэтгэлцэж байна.

Хурандаа Э.Батбаяр:

- Манай албаны зүгээс боломжийн хэмжээгээр анхаарья.

Шүүгч С.Амардэлгэр:

- Танай боловсон хүчний тогтвор суурьшил муу байгаа нь танай ажилд их нөлөөлдөг байх гэж боддог.Чадалтай өмгөөлөгч нар шүүх хуралд орж байна, тийм болохоор боловсон хүчнээ чадавхжуулах шаардлагатай.Шийдвэр гүйцэтгэх ажиллагаа гэдэг бол бүхэлдээ процесс ажиллагаа шүүх гомдол гаргагчийн нэхэмжлэлд дурьдаагүй ч гэсэн бусад ажиллагааг зайлшгүй үзэх шаардлагатай болдог.Саяхан би үнэлгээ хүчингүй болгуулах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэхдээ албадан дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэсэн.

Шүүгч Б.Золзаяа:

- Танай байгууллага өртэй этгээдийн бүртгэлд нилээн ач холбогдол өгөх хэрэгтэй.

Хурандаа Э.Батбаяр:

- Манай албанаас өртэй этгээдийн бүртгэлийн судалгааг сар бүр гаргаж Шийдвэр гүйцэтгэх газарт хүргүүлдэг. Одоогийн мөрдөж буй хуулиар өртэй этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн этгээдийн мэдээлийг ШШГЕГ олон нийтийн мэдээллийн хэрэгслэлээр зарлах эрх нь байгаа.

Дэд дарга Ч.Оюунцэцэг:

- Шийдвэр гүйцэтгэгч нар нотариатын зардлыг хувиасаа гаргадаггүй, албан дээр манай байгууллагатай гэрээтэй нотариатч түрээсийн мөнгө төлөхгүйгээр шийдвэр гүйцэтгэгч нарын шүүхэд гаргах нотлох баримтыг үнэгүй батагаажуулж өгдөг.Мөн албадан дуудлага худалдааны талаар шүүхэд их гомдол гаргадаг. Ялангуяа 2 дах албадан дуудлага худалдааны талаар, манай албанаас албадан дуудлага худалдаа явуулахдаа Иргэний хуулийн 177.4 заасан шаардлагын хэмжээгээр нийтэд мэдээлж байгаа, шүүх ч хуульд нийцсэн байна гэж нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байсан. Сүүлийн үед шаардлагын хэмжээгээр зарласан байхад УДШ-с албадан дуудлага худалдааг хүчингүй болгож шийдвэрлэж байна.Үүн дээр нэг мөр ойлголттой болмоор байна. Бас хөрөнгө хамгаалах захирамж /ИХШХШТХуулийн 69/-ийг ирүүлэхдээ иргэн бол РД-г, хуулийн этгээд бол Улсын бүртгэлийн дугаарыг бичиж ирүүлж байх шаардлагатай байна.

Шүүгч Б.Золзаяа:

- Бид УДШ шийдвэрт үнэлэлт дүгнэлт хийх эрх байхгүй, танай албанаас УДШүүхэд хандаж болно.Хуулинд өөрчлөлт ороогүй нөхцөлд хүндрэлтэй байна.Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах захирамжид РД болон УБД-г бичиж явуулж байх боломжтой.

Шүүгч С. Амардэлгэр:

- Албадан дуудлага худалдааны зар гаргахдаа үнэ тавьдгаараа тавиад харин 2 дах албадан дуудлага худалдааны тогтоолын агуулга, найруулгыг засмаар санагдсан.

Шүүгч Г. Билгүүн:

- Албадан дуудлага худалдааны зар гарч байна, эд хөрөнгийн хаягийг ҮХЭХ-ийн гэрчилгээний хаягаар биччихэж болдоггүй юм уу, хавь ойр орчинд байдаг зүйлийг биччихсэн байдаг, мөн хоёрхон хуудас нотлох баримт авчирч өгдөг, нотлох баримт шаардахаар урьд шүүгч нар ингэж аваад болдог байсан гэж юу ч мэдэхгүй хүнтэй ярьж байгаа юм шиг ярьдаг, бид 1 л хуулинд захирагддаг шүү дээ, үүн дээр анхаарах хэрэгтэй.

Шүүгч С.Амардэлгэр:

- Шийдвэр гүйцэтгэгч ажиллагаа болгоныг сайн баримтжуулах хэрэгтэй.

Шүүгч Б.Золзаяа:

- Дуудлага худалдааны зар дээр танай байгуулага ҮХЭХ-н байршилыг гэрчилгээн дээрх хаягаар нь бичиж албажуулж гаргаад, харин хаалтан дотор олон сонирхогч татах үүднээс ойр орчны мэдээллийг бичиж реклам хийх хэрэгтэй. Зарыг ингэж нийтлэх нь буруу биш юмаа.

Дэд хурандаа Ч.Оюунцэцэг:

- Шүүх хуралдааны тов мэдэгдсэн зарыг танай зарлага шийдвэр гүйцэтгэгч нарыг ажиллагаанд гарсан хойгуур авчирч өгдөг, үүнийг өглөө 9 цагт юмуу, эсвэл 17 цагт авчирч өгмөөр байна, бас итгэмжлэгдсэн төлөөлөгчөө томилж ирүүлэнэ үү гэсэн мэдэгдэл ирдэг, энэ мэдэгдэлд төлбөр төлөгч авагч нь хэн нь тодорхойгүйгээс хэн гэдэг шийдвэр гүйцэтгэгчийг томилох нь тодорхойгүй, цахим бүртгэлээс шүүлт хийх боломжгүй хугацаа алддаг. Энэ тал дээр анхаарч өгөөчээ.

Шүүгч Б.Золзаяа:

- Манай зарлага зарлан дуудах мэдэгдлийг заавал шийдвэр гүйцэтгэгчид өгөх шаардлагагүй танай бичиг хэрэгт хүлээлгэж өгөхөд л хангалттай, харин манай шүүх зарлан дуудах мэдэгдлийн загварыг өөрчлөх хэрэгтэй юм байна. Төлбөр төлөгч, төлбөр авагчийн нэрийг тодорхой бичиж явуулж болноо.

Шийдвэр гүйцэтгэгч П.Хадбаатар:

- Гомдол гаргагч нэг асуудлаар олон удаа гомдол гаргаж байна, миний ажиллагаа явуулж буй хэрэгт нэхэмжлэл гаргах эрхгүй этгээд удаа дараа нэхэмжлэл гаргаж шүүхээс хэрэгсэхгүй болгож шийдвэрлэж байна. Энэ болгонд шүүх шийдвэрлэтэл хугацаа маш их алдаж төлбөр төлөгчид боломж их олгож байна.

Шүүгч Б.Золзаяа:

- Шүүх нэхэмжлэлийг хүлээж аваад буцаах уу, татгалзах уу, гэдгээ заавал шүүх хуралдаан дээр л шийдвэрлэдэг. Бид тухайн этгээдийг удаа дараа гомдол гаргаж байгааг мэддэг хэдий ч хувийн болон албаны өөр замаар авсан мэдээллийг хувийн амбицаар үнэлэх эрхгүй, хөндлөнгийн байр сууринаас хандах ёстой байдаг.

Хурандаа Э.Батбаяр:

- Шүүхээс шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлэх захирамж их ирдэг. Тухайлбал Шүнди ХХК-тай холбоотой асуудлаар манай албатай холбогдуулан гаргасан нэхэмжлэлийг урьд өдөр нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байхад маргааш нь өглөө нь шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн захирамж ирдэг.

Шүүгч Б.Золзаяа:

- Дэлхий нийтийн жишиг хуулиар зээлдүүлэгчийн эрх ашгийг хамгаалдаг, харин ШШШГТХуулиар төлбөр авагчийн эрх ашгийг хамгаалж байдаг. Түдгэлзүүлсэн захирамжийн талаар танай байгууллага хөндлөнгийн дүгнэлт гаргах эрхгүй.

Шүүгч Ө.Уянга:

- Шийдвэр гүйцэтгэгч нарыг сайн сургалтанд хамруулмаар байна, шүүх хуралдаанд мэтгэлцэж оролцох шаардлагатай. Шийдвэр гүйцэтгэгч нар дуудсан цагт ирэхгүй, шүүх хуралдаан удаа дараа хойшилж байгаад анхаарах хэрэгтэй.

Хурандаа Э.Батбаяр:

- Шүүгч нараас сургалт авмаар байна, ялангуяа кейс маягаар сургалт авмаар байна, манай алба өнгөрсөн жил л гэхэд шийдвэр гүйцэтгэгч нарын 3-ны 1 хувь нь шинээр томилогдож, өөрчлөлт хөдөлгөөн хийгдсэн, сургалт зайлшгүй шаардлагатай, бид 5 дугаар сард шүүгч, банкуудын холбоо, бүртгэлийн байгууллага, хөрөнгийн үнэлгээний байгууллага оролцуулсан албадан дуудлага хуудалдааны талаар нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулах төлөвлөгөөтэй байгаа.

Шүүгч Б.Золзаяа:

- Нэгэнт хуулинд өөрчлөлт оруулаагүй цагт хичнээн хэлэлцүүлэг зохион байгуулаад үр дүнгүй, харин сургалт зохион байгуулвал зүгээр санагдаж байна. Бид өнөөдөр танайх тийм манайх тийм гэхээсээ илүү ямар арга замаар шийдвэрлэх вэ гэдэг гарцыг хайх хэрэгтэй.

Хурандаа Э.Батбаяр:

- Хууль тайлбарлах, хууль хэрэглээний талаар, хуульзүйн фактууд гэх мэтчилэн асуудлаар сургалтын хөтөлбөр боловсруулаад 5 дугаар сарын эхээр сургалт авья.

Ахмад Б.Дашдаваа:

- Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгажуулах захирамжаар банкны дансны зарлагын гүйлгээг зогсоохоор захирамжилдаг. Энэ явсаар шүүхийн шийдвэр гарч ирдэг. Энэ тохиолдолд шийдвэр гүйцэтгэх ажиллагаа явуулахаар банкинд хандаж дансны үлдэгдэлийг лавлахад банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2-д зааснаар танай байгууллага лавлагаа авах албан тушаалтан биш гэдэг үндэслэлээр мэдээлэл авах боломжгүй байдаг. Иймд хөрөнгө хамгаалах захирамж нь шүүхийн шийдвэр биелэгдэхийн үндсэн нөхцөл болж байдаг. Иймээс хөрөнгө хамгаалах захирамж гаргахдаа банкны дансны дугаарыг бичиж ирүүлж байвал сайн байна.

Шүүгч Б.Золзаяа:

- Хөрөнгө хамгаалах захирамжид банкны дансыг дурьдаж явуулж болно.

Хурандаа Э.Батбаяр:

- Өнөөдрийн зөвлөлдөх уулзалт үр дүнтэй сайхан болж өнгөрлөө. Та бүхэнд ажлын амжилт хүсье. Зөвлөлдөх уулзалт 11 цаг 30 минутад өндөрлөв.

Протокол хөтөлсөн: ахмад

Ц.Бямбасүрэн